

2008.02.28

Дугаар 37

“Жавхлант-Алдар хаан ББСБ” ХХК-д банк бус  
санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Жавхлант-Алдар хаан ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ж.Жадамбаа/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ